

ДеФакто **ТОЙМ**

➤ МАЛЫГ ХӨЛӨӨР
НЬ ГАРГАХГҮЙ

➤ ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН
ХУУЛЬ ХЭНД АШИГТАЙ ВЭ?

➤ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ДУУ
ХООЛОЙ ХУМИГДАХ УУ?

IX НҮҮРТ



ДеФакто **НИЙТЛЭЛ**

Д.Жаргалсайхан
Эдийн засагч, нийтлэлч

БИД
АРДЧИЛЛААС
← **УХАРЧ БАЙНА** →

II НҮҮРТ



САЙН ЗАСАГЛАЛ

О.Мөнхбат
Доктор, МУИС-ийн Профессор

Зөвлөх зөвлөх
нь "зөв" үү?

IV НҮҮРТ

WEEKLY

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

| ЗОРИГЖУУЛНА

| МЭДЭЛЖҮҮЛНЭ

Баасан, 2019.06.21, №10 (102)

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ, БИЕ ДААСАН,
УЛС ТӨРИЙН НАМААС ХАРААТ БУС, ДОЛОО ХОНОГ ТУТМЫН ГЛОБАЛ СОНИН

www.defacto.mn



БИД АРДЧИЛЛААС
← **УХАРЧ БАЙНА** →



Дамбадаржаагийн ЖАРГАЛСАЙХАН

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

БИД АРДЧИЛЛААС УХАРЧ БАЙНА

Иргэдийн дийлэнхийн сонголтоор төр засгаа байгуулахыг ардчилал гэдэг. Хууль тогтоох, хэрэгжүүлэх, шүүх засаглалаас бүрддэг ардчилсан төр засаг нь иргэдийн худалдаа, бизнесийн эрх чөлөөг хангаж, тэдний эрх, аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалж чадаж байвал иргэдийн амьдрал дээшилж, улс орон нь хөгжих боломжтой.

Гэхдээ дийлэнхийн шийдвэр гэдэг нь бүх иргэдийн шийдвэр бас биш учир нийгэм нэг цул бүтэц биет шиг ажиллах боломжгүй (John Lock). Тийм учраас олонхын шийдвэр тодорхой хугацаанд эерэг үр дүн авчрах боловч, тодорхой нөхцөл байдалд сөрөг үр дагавар нь илрэн гарч ажиллах горимоо өөрчлөх, засч сайжруулах шаардлага гардгийг түүх харуулж байна.

Энэхүү хөөрч буусан, давшиж ухарсан үйлдлийг Харвардын Их Сургуулийн эрдэмтэн С.Хантингтон “ардчиллын давалгаа” гэж тодорхойлжээ. Том зургаар нь харвал хүн төрөлхтөн эдүгээ гурав дахь давалгаанаасаа бууж “ардчиллаасаа ухарч” байгаа ажээ.

ГУРАВ ДАХЬ ДАВАЛГАА

Ардчиллын гурав дахь давалгаа зуун шилжихэд 110 орныг хамарсан байлаа. 90-ээд оноос олон арван орон авторитари, тоталитари дэглэмээс ардчилсан дэглэм рүү шилжсэн. Гэвч 2006 оноос энэ шилжилт зогсож, Стэнфордын профессор Л.Даймондын хэлснээр зарим орон ардчиллаас ухарч (democratic backsliding) эхэлжээ. Ардчиллын ухралт нь цэргийн эргэлт хийх, сонгуулийг санаатайгаар луйвардах, намууд сонгуулиар засгийн эрхэнд гармагцаа хуулиар дамжуулж ардчиллын инстүүцүүдийг сулруулах, гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох болон шүүх засаглалд ноёрхлоо тогтоох зэрэг дөрвөн хэлбэрээр явагдах болжээ.

Аль ч хэлбэрээр нь явсан юуны өмнө иргэний нийгмийн дуу хоолойг хааж боогдуулах буюу

Эхний давалгаа нь 1826-1920 онд, АНУ-д эрэгтэйчүүдэд төрд төлөөллөө сонгох эрх анх олгосноор эхэлж яваандаа Франц, Англи, Канад гэх мэт хөгжилтэй 30-аад орныг хамарчээ. 1922 онд Италид Бенито Муссолини төрийн эрхэнд гарснаас эхний давалгаа суларч ардчиллын ухралт эхэлжээ.

Хоёр дахь давалгаа нь дэлхийн II дайны дараа эхэлж 20-оодулс орон төдөлгүй ардчилалд шинээр нэгджээ. Давалгаа багасч, урсгал харьцангуй тогтмол болсны гол шалтгаан нь эмэгтэйчүүд сонгох эрхгүй байсантай холбоотой. Анхны давалгаанд хамрагдсан Швейцарьт гэхэд л дөнгөж 1971 онд эмэгтэйчүүд сонгох эрхээ олж авав.

Гурав дахь том давалгаа 1974 онд Португалд лиш (carnation) цэцгийн хувьсгалаар эхэлж, 80-аад онд, Латин Америк, Зүүн Азийн орнуудад, 90-ээд онд ЗХУ задран унаснаас хойш зүүн Европын орнуудад үргэлжлэв. Энэхүү гурав дахь том давалгаа, өмнөхийн адил, 2001 оны 9-р сарын 11-ий дэлбэрэлтийн дараа АНУ “терроризмийн эсрэг дайн” зарласнаар суларч эхэлжээ. 2008 оны их хямралаас хойш Тайланд, Филиппин, Турк, Польш зэрэг олон улс ардчиллаас ухарсан, улс орон бүрт өөрийн ардчиллын давалгаа байгаа гэж зарим судлаачид үзэж байна.

иргэдийн эвсэн нэгдэх, жагсах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг шууд ба шууд бусаар хязгаарлаж байна. Иргэний нийгмийн үндэс тулгуур болох төрийн бус байгууллагуудын тухай хууль тогтоомжуудыг өөрчлөх, санхүүжилт, үйл ажиллагааг нь хянах, хязгаарлах замаар устгахыг оролдох боллоо. Энэ үйлдэл сүүлийн дөрвөн жилд 60-аад оронд гарлаа.

Пост коммунист орон зайд ТББ-ын үйл ажиллагааг хамгийн түрүүнд, хамгийн үр дүнтэй хязгаарлаж тарааж чадсан улс бол манай хоёр хөрш юм. Сүүлийн үед энэ шахалт Монголд ч эхэлж байна.

ОХУ-д “Гадаадын агентуудын чиг үүргийг гүйцэтгэж буй Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах хуулийн нэмэлт өөрчлөлт” гэдэг нэртэй

► хууль 2012 онд батлагдаж ТББ-ын үйл ажиллагаа, санхүүжилтийг хязгаарласан. Энэ хуулиар гадаадаас санхүүжилт авч байгаа болон, улс төрийн үйл ажиллагаа явуулж байгаа ТББ-ууд гадаадын агент гэж бүртгүүлэх ёстой болж, тэдэнтэй хууль зүйн яам нь “тулж” ажилладаг болов. Олон улсын байгууллагуудын зүгээс маш их шүүмжлэл сонсдог энэ хуулийг В. Лукин гэдэг иргэн 2013 онд Үндсэн хуулийн шүүхэд өгч үзсэн боловч, хэвээр үлдээжээ.

*1990 оноос ардчилалд шилжсэн,
хамгийн тогтвортой гэж үзэж байсан Унгар,
Польш зэрэг орнууд ардчиллаас ухрах болсон нь
гайхал төрүүлж байна.*

Унгарт төрийн бус байгууллагуудыг хааж, Ж.Соросын Нээлттэй нийгэм санг ард түмний дайсан гэж Ерөнхий сайд В.Орбан зарлав. Европ руу цагаачдыг гаргахыг уриалсан учир энэ санг үндэсний аюулгүй байдалд аюул занал учруулж байна гэж үзжээ. 2016 оны 4-р сард Дээд боловсролын тухай хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулснаар Соросын сангаас санхүүждэг Төв Европын их сургуулийг шахаж улсаасаа хөөн гаргав (Зулека 2018). Унгар мөн 2017 онд “Гадаадын дэмжлэгтэй байгууллагуудын ил тод байдлын тухай” хууль гаргаж 23 мянган еврогоос илүү санхүүжилттэй байгууллагуудыг өөрийн вебсайт, танилцуулга, хэвлэмэл материалууд дээр хандивлагч бүрээ дурдах шаардлага тавьсан (Женсен, 2017). Энэ шаардлагыг биелүүлээгүй бол 2900 еврогийн торгууль ногдуулна. Давтан үйлдвэл

ХАРИН МОНГОЛД

Монгол улс Төрийн бус байгууллагын тухай анхны хуулийг 1997 онд баталжээ.

2019 оны 6-р сарын байдлаар манайд 21,040 төрийн бус байгууллага бүртгэлтэй ч, 8500 нь буюу талаас бага нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Гэвч эдгээр байгууллагууд ашгийн бус, нийтэд тустай үйл ажиллагаа голлон эрхэлдэг, харин хөгжингүй орнуудад түгээмэл дэлгэрсэн нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, төрийн үйл ажиллагаа хянах талаар ажилладаг нь цөөхөн байна гэж монголын төр засаг үздэг ажээ.

ХЗДХ Яамны Хууль зүйн бодлогын хэлтсийн дарга П.Сайнзоригийн илтгэлд дурдсанаар ТББ байгаль орчин, нийгмийн халамж үйлчилгээ, боловсрол, улс төр, шашин гэх мэт бүх салбарт ажиллаж байна. Үүнээс дийлэнх нь уул уурхайтай холбоотой эсвэл энэ салбар, чиглэлд үйл ажиллагаа эрхэлж байна гэжээ. Тийм учраас ТББ-аас гадна Ашгийн бус байгууллагын тухай хууль хэрэгтэй байна гэж тэр хэлэв. Цаашлаад манай төрийн бус байгууллагууд гадны төлөөлөгчийн газрууд шиг болсон учир санхүүжилтийг нь төрөөс

тухайн байгууллагыг татан буулгах болов. Үүнийгээ мөн л мөнгө угаах, террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхийн эсрэг бодлого гэж үзэж байна.

Харин Польш улсад 2017 оны 9-р сард Ерөнхий сайдад шууд тайлагнадаг Иргэний нийгмийн хөгжлийн үндэсний төв гэх агентлагийг шинээр байгуулсан. Энэ төв нь Засгийн газрын болон Европын, бусад олон улсын байгууллагуудын ТББ-уудад зориулсан төсөв санхүүг хуваарилах болов. Польшийн эрх баригч намаас ТББ-уудыг муу (либерал), сайн (консерватив) гэж хуваах болов (Сианетти, Давсон, Ханлий, 2018). Засгийн газрын үйл ажиллагааг дэмждэггүй ТББ-ууд хүнд цохилт авлаа. Гадаадын дэмжлэгтэй ТББ-уудад бүр сөргөөр нөлөөлж байна. Польшид нийгмийн цөөнхийн асуудлыг илэрхийлдэг ТББ-уудын хувьд нөхцөл байдал улам хэцүү болжээ (Зулека, 2018). Үүнд арьс өнгөөр ялгаварлахыг эсэргүүцдэг, цагаачлалыг дэмждэг, “Watch Dog”-ны үүрэг гүйцэтгэдэг байгууллагууд юуны өмнө орж байна. Мөн Польшийн Засгийн газар олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглаж нийгэмд ТББ-уудын нэр хүндийг унагаах ажил хийж байна. Эрх баригчдыг шүүмжилсэн ТББ-уудын төлөөллийг хянаж, шалгах болов. 2016 оны 10-р сард Үр хөндөлтийг хориглосон хуулийн эсрэг жагсаал цуглааныг зохион байгуулсан хүмүүсийн баримт бичиг, компьютер зэргийг шалгасан (Иргэний нийгмийн тогтвортой байдлын индекс, 2018).

дэмжих хэрэгтэй гэлээ. Мөн дэд сайд асан Б.Энхбаяр тийм хуулийн төслийг бэлдэж, манай төрийн бус байгууллагуудын 80 хувь нь гадаадаас санхүүжилт авдаг. ТББ-ыг хянахгүй, үнэлгээ дүгнэлт хийхгүй бол мөнгө угаах, терроризмын гэмт хэргийн эрсдлийг өндөр болгож байна гэжээ. Тийм учраас монголын төр ТББ-уудыг “цэгцлэх” ажилд ханцуй шамлан орж байна.

*Манайх шиг залуу ардчилсан оронд ТББ-уудын
санхүүжилт, бүтэц, зохион байгуулалт бэхжиж,
хөгжөөгүй байна. Ийм үед нь ТББ-ын гадаадын
санхүүжилтийг хаах нь үйл ажиллагаагаа зогсооход
хүргэх юм. Манай улсад филантропийн соёл бий
болоогүй байна.*

Ийнхүү олон оронд ардчиллаас ухрах үйл явдал өрнөж байна. Монголд сүүлийн хоёр, гурван жил өрнөж буй бүх үйл явдлуудыг нэгтгээд харвал ардчиллаас ухраад эхэлсэн гэж дүгнэж болно. Одоо хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллагууд дуу хоолойгоо нэгтгэх цаг.

2019.06.19



НИЙТЛЭЛ

О.МӨНХБАТ

Доктор, МУИС-ийн Профессор

Зөвлөх зөвлөх нь "зөв" үү?

Бид байнга ямар нэг асуудлаар сонголт хийж шийдвэр гаргаж байдаг. Хүн бүр л ингэдэг. Төр засаг, эрх мэдэл бүхий албан тушаалтан ч мөн ингэдэг. Харин ялгаа нь гэвэл хувь хүн буруу шийдвэр гаргавал "өөрөө унасан хүүхэд уйлдаггүй" гэдэг лугаа өөрөө л хохирно. Харин төр засаг буруу бодлого, шийдвэр гаргавал "нэг үхрийн эвэр доргиход мянган үхрийнх доргино" гэдгээр нийгэм, төр улс хямрах, доройтох тэр бүү хэл сөнөж устдагийг буурал түүх харуулдаг.

БОДЛОГО, ШИЙДВЭР ГЭЖ ЮУ БОЛОХ?

Бодлого, шийдвэр гаргалт гэдэг хоёр ойлголт салшгүй зүйл аж. Бодлого гэдгийг аливаа нэг зүйлийг хийх, эс хийх шийдвэр гаргалт хэмээн тодорхойлж болно. Энэ талаар эрдэмтэд ижилдүү санал бодолтой болох нь доорх ишлэлүүдээс харагдана.

- Pal Leslie: "Тухайн нэг асуудал болон бүлэг асуудлыг шийдвэрлэхээр төр, засгийн эрх бүхий албан тушаалтан\байгууллагын сонгон авсан үйлдэл эс үйлдэл" (Pal, 2013)
- Howlett M, Ramesh, M: "Төрийн бодлого гэдэг нь төр, засгаас хийхээр сонгон авсан үйлдэл" (Howlett.M, 2009)
- Thomas Dye: "Төрийн хийхээр болон эс хийхээр шийдвэрлэсэн үйлдэл" (Thomas R, 1973)

Ийм том дэнчинтэй тул төр засаг бодлого, шийдвэр гаргахдаа "долоо хэмжиж, нэг огтлохоос" аргагүй болно. Төрийн алба, судалгаа, боловсролын байгууллагуудтай, зөвлөх, зөвлөх үйлчилгээтэй, хууль тогтоомж, хэм хэмжээтэй том тогтолцоо зөв шийдвэр гаргахын төлөө ажилладаг. Ингэж шийдвэр гаргахуйн аюулгүй байдлыг хангахыг зорино.

"Бодлого боловсруулна гэдэг нь бүх нийгмийн гишүүдийн (иргэд, институту) үйл ажиллагаагаа явуулах хүрээ хязгаарыг тогтоох болон нийгмийн үндсэн зорилго, түүнд хэрхэн яаж хүрэх хамгийн сайн арга замыг тодорхойлон шийдэх үйл явц" (Young, 2013) аж.

Эдгээрээс харахад бодлого гэдэг аливаа нэгэн асуудлаар тодорхой үйлдэл хийх эсэхээ шийдвэрлэх буюу өрнөдийн Маркс гэгддэг социологич М.Веберын хэлсэнчлэн "үйлдэл, зориудын эс үйлдэл"-ийг сонгоно гэсэн үг.

Төр засаг тухайн асуудлаар юу хийж юуг эс хийхээ шийдэх нь нэг ёсондоо төрийн бодлого болж хувирч байна. Бодлогын мөн чанар тэгэхээр аливаа нэг болон багц асуудлыг шийдэхэд төвлөрсөн, түүнийг шийдэхээр сонгосон үйлдэл, эс үйлдлийг чиглүүлэх зорилго, зорилт, хүрэх үр дүн болох нь.

ХЭН ШИЙДВЭР ГАРГАДАГ ВЭ?

Хэн шийдвэр гаргадаг вэ гэхээр бид ихэвчлэн төр засаг гэж хариулдаг. Чухамдаа эрх мэдэл бүхий албан тушаалтан бодлого сонгон шийдвэр гаргана. Эрх мэдэл гэдэг нь нийгмийн хамгийн хомс баялаг тул хүн бүр хүртэж чаддаггүй хяслантай зүйл учраас эрх мэдэлтэй нь цөөхүүлээ. Ийм ч учраас тэд хуулийн дагуу ямба эдэлнэ. Мөн "Ямбыг нь ч эдэлнэ ялыг ч үүрнэ" гэдгийн

адилаар тэд хариуцлага үүрэх ёстой. Харин нийгэмд учруулсан хор хохиролтой харьцуулах юм бол тэдний хүлээх хариуцлага өчүүхэн мэт санагдана. Жишээлбэл, нэг нөхөр хазаар гүйлгэж айлын адуу хулгайлж, хуушуурын гуанзанд зарчихаад баригдвал хохирлоо барагдуулахын хамт "аавын хаалга" татна. Харин Засгийн газрын алдаатай бодлогын төлөө хамгийн сайндаа эрх

мэдэлтэй хэн нэгэн албан тушаалаасаа огцорно. Хохирол энэ тэрийг бол барагдуулахгүй. Яагаад гэвэл хуулийн дагуу бид тэдэнд эрх мэдэл, албан тушаал өгөхдөө бас “санаатайгаар бус алдаа” гаргах эрхийг хамт өгдөг аж.

Шийдвэр гаргагч гэж хэн болохыг хууль тогтоомжид юу гэж заасныг үзье.

ШИЙДВЭР ГАРГАХУЙ ГЭЖ ЮУ БОЛОХ

Шийдвэр гаргах үйл явц гэдэг нь аливаа нэгэн асуудлаар шийдвэр гаргах эрх бүхий этгээд юуг хийх, юуг эс хийхээ буюу бодлогоо сонгох үйл явц гэж ойлгоё. Энэ үйл явц асуудлаа тодорхойлж судлан шинжлэх, шийдлийн хувилбар боловсруулах, тухайн хувилбаруудаас сонголт хийх гэсэн замаар явна. Энэ бол алхам алхмаар шийдвэр гаргах үйл явц агаад эрдэмтэн судлаачдын санаа бодлыг тоймлон дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

Алхам 1. Асуудлаа тодорхойлж, судалгаа хийнэ: чухам юуг шийдэх, яагаад шийдэх ёстой вэ гэдгээ тодорхойлно. Бодлого шийдвэр гаргахтай холбоотой судалгаа шинжилгээ хийнэ. Энд ямар мэдээлэл шаардлагатай болох, мэдээллийн эх сурвалж; тухайн мэдээллийг хэрхэн олж авах арга замаа тодорхойлон ажиллана. Мөн мэдээлэл, нотолгоог үнэлэн цэгнэх буюу бодлогын хувилбар бүрээр мэдээ нотолгоог үнэлнэ гэсэн үг.

ШИЙДВЭР ГАРГАХУЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ:

Шийдвэр гаргахад шууд болон шууд бусаар оролцогч талууд улс орны аюулгүй байдал, улс үндэсний язгуур эрх ашиг, тусгаар тогтнол, ард олны сайн сайхан байдалд нөлөөлж байдгаараа онцлог. Төрийн бодлого, шийдвэр гармагц нийгмийн хомс баялагийг дайчлан хэрэгжүүлдэг бөгөөд үр дагавар нь улс орон, нийгмийн бүлэг давхраанд шууд болон шууд бусаар нөлөөлж эхэлнэ. Алдаатай буруу бодлого шийдвэр их бага ээлтгүй аажмаар засч боломгүй алдаа, асар их үнэ төлөхөд хүргэдэг тул аливаа нийгэм шийдвэр гаргахуйн аюулгүй байдалд онцгой анхаардаг.

Төрийн бодлого, шийдвэр гаргахуйн аюулгүй байдлын тогтолцоо чухамдаа “хатуу, зөөлөн” хүчнээс бүрддэг гэж хэлж болно. **“Хатуу хүч”** гэж эрх, чиг үүрэг, хариуцлага дээр суурилсан, бүгд заавал даган мөрдөх хэм хэмжээтэй төрийн алба түүний дотор судалгаа, шинжилгээ, хууль хяналт, тагнуул зэрэг институтийг хэлнэ. Энэ хүч нь төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах бүхий л үе шатанд оролцох чиг үүрэгтэй, түүний хэрэгжүүлэх эрх мэдэл, хөрөнгө хүч, хүний нөөцөөр хангагдсан байдгаараа шийдвэр гаргах аюулгүй байдлын тулгуур болно. Нийгмийн зүгээс “ташуур болон танзуурын” тусламжтайгаар буюу цалин хөлс, эрх мэдэл, гавьяа шагнал болон шийтгэл зэргээр тэднийг хийж буй ажлынхаа үр дагаврын төлөө хариуцлага хүлээх нөхцөл бүрдүүлнэ.

Зөвлөлдөх санал асуулгын тухай хуульд зааснаар бол “шийдвэр гаргах эрх бүхий этгээд” гэж хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн бүх шатны байгууллага, хуулиар тусгайлан олгосон бүрэн эрхийн дагуу захиргааны хэм хэмжээний акт гаргах нийтийн эрх зүйн бусад этгээд, бүх шатны нутгийн өөрөө удирдах байгууллага (УИХ, 2017) аж.

Алхам 2. Шийдлийн хувилбар боловсруулна. Тухайн асуудлаар хэд хэдэн шийдвэр байж болох буюу хувилбаруудтай байна. Бодлого шийдвэр нь хууль тогтоомжтой нийцэх эсэх, ямар зардал, нөөц шаардлагатай болох, ямар үр дүнд хүрэх, арга зам зэргээ тооцно.

Алхам 3. Хувилбаруудаас сонголт хийнэ. Ингэхдээ зөвхөн нэгийг сонгох, эсвэл хэд хэдэн хувилбарыг хослуулах байдлаар сонголт хийж болно. Цаг хугацаа, хүн хүч, хөрөнгө мөнгө бол нөгөө л нийгмийн хомс баялаг тул “Хүн хэрээрээ, тэмээ тэнгээрээ” гэдэг зарчмаар сонголт хийх, алдаа эрсдлээс сэргийлэхийн тулд энэ алхмыг хийнэ.

Алхам 4. Хэрэгжүүлэх, хянан магадлах, үнэлэх. Хэрэгжилтийг хангахын хамт гаргасан бодлого шийдвэрээ хянан шүүж, алдаа байвал бага дээр нь засч залруулна.

Харин **“зөөлөн хүч”** гэж бодлого боловсруулах, шийдвэр гаргахад зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хувийн, төрийн бус, олон улсын байгууллага болон хувь хүмүүсийг хэлэх бөгөөд тэд шийдвэр гаргагчийг алдахаас сэргийлж, зөв шийдвэр гаргахад шинжээчийн байр сууринаас оролцоно. Энэ хүч нь аливаа бодлого шийдвэрийн хэрэгцээ шаардлага, үндэслэл, хувилбар боловсруулахад шаардлагатай мэдлэг, ур чадвар, туршлагыг шийдвэр гаргагчаас хараат бусаар нийлүүлж байдгаараа маш чухал ач холбогдолтой. Харин шийдвэр гаргахад нөлөөлдөг атлаа хуулийн гэхээсээ илүүтэй ёс зүйн хариуцлага хүлээдгээрээ онцлог. Тэд зөвлөж харин эцсийн шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан, байгууллага гаргадаг.

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ БОЛОХ

Бидний ойлгож буйгаар зөвлөх гэдэг нь “олон салбарын мэдлэгтэй, нарийн мэргэшсэн, шаардлагатай мэргэжил, туршлага бүхий хувь хүн болон хуулийн этгээд” байгууллага [аж](#).

Социализмын үед монголд “зөвлөлтийн мэргэжилтэн”-ээр зөвлөхөө хийж, зөвлүүлдэг байлаа. Бид тэднээс их юм сурсан, багагүй мөнгө төлсөн. Их өрийн тодорхой хэсэг “зөвлөлтийн мэргэжилтний” цалин хөлс, хангамжид явсан нь ч бас үнэн. Харин шинэ үеийн монголын төр засгийн хувьд “төсөл”, “зөвлөх, зөвлөх үйлчилгээ” гэдэг ойлголтыг 1990-ээд оны үеэс олон улсын донор байгууллагууд анх оруулж ирэв. Шинэ нийгэмд шилжихэд мэдэхгүй чадахгүй юм их гарч ёстой л “нохойн битүү туурай, ногоон хурганы арьс” гэдэг шиг нүд бүлтийлгэж, чих дэлдийлгэсэн зүйлс олонтоо учирсан он жилүүд байлаа. Шинэ содон зүйлийг, тэгээд бас анх удаа хийж байхад эдгээр зөвлөхүүд, тэдний зөвлөгөө саналууд монголчуудад хэрэг болсон, бид ч тэднээс их зүйл сурсан гэдэг бас нэг үнэн. Гэхдээ энэ бүхэн үнэ төлбөргүй байгаагүй, донор байгууллагуудаас авсан буцалтгүй тусламж, зээлийн тодорхой хэсгийг үүнд зарсан нь ч бас үнэн.

Өнөөдөр монголд зөвлөх, зөвлөх үйлчилгээний хоёр төрлийн тогтолцоо байна гэж үзэж болно.

Нэгдүгээрт, Монгол улс “төр, орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” зэрэг хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагддаг, сонгон шалгаруулалтаар

шалгаруулдаг, зорилго, зорилт, хүрэх үр дүн, хийх ажил, хугацааг заасан ажлын даалгавартай (ToR гэх нь бий), эргэн тайлагнадаг зөвлөх үйлчилгээний тогтолцоо байна. Энэ тогтолцоо, түүний хууль эрх зүйн орчин хэдийгээр улс төрчдийн ашиг сонирхлын зөрчлөөс үүдэн олонтоо өөрчлөгддөг ч сайнтай муутай үүргээ гүйцэтгэж байна.

Хоёрдугаарт, Төр засгийн бараг бүх шат дахь “зөвлөх” гэсэн албан тушаалын тогтолцоо. Анхлан Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газрын гишүүд зөвлөхтэй болов. Дараа нь агентлаг, газрын дарга нар зөвлөхтэй болов. Зөвлөхүүд бас “орон тооны” болон “орон тооны бус” гэгдэнэ. Мөн зөвлөх даалгавартай ажлын хэсгүүдийг байгуулдаг болов. Харин зөвлөхийн статус нь тодорхойгүй хэвээр, гагцхүү Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайдын зөвлөхийг “Төрийн албаны тухай” [хуулиар](#) төрийн улс төрийн тушаалтан гэж тодорхойлноос өөр тоймтой зүйлгүй. Тэд төсвөөс цалинжиж, албан өрөө, унаа тэрэгтэй, эрх мэдэл, нэр нөлөөтэй гэдэг нь олонд ил. Энэ ч зөв. Төрд зөвлөх ажлыг “сайн дурын” цалин хөлсгүй, буяны үйлс мэтээр харж болохгүй. Хэрэв тэгвэл хариуцлага тооцох ямар ч үндэслэлгүй болно, учир нь сайн дураараа ажиллаж бас цалин хөлс аваагүй учраас. Хэрэв ингэвээс шийдвэр гаргах үйл явц бүхэлдээ аюулд орно. Гол нь Төрийн албаны тухай хуульд заагаагүй энэ олон зөвлөхүүдийг яаж сонгодог, тэдэнд ямар шаардлага тавьдаг нь маш тодорхойгүй байна.

ЗӨВЛӨХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ЮУНЫ ТУЛД БАЙДАГ ВЭ?

Төрийн бодлого шийдвэр гаргахад нөлөөлдөг “зөөлөн хүч” яагаад хэрэг болдгийг судлаачид дараах байдлаар тайлбарладаг. Үүнд:

1. Хөндлөнгийн, хараат бус байр суурийг сонсох боломж олгоно. Эрх мэдлийг “Даннинг-Крюгерийн үр нөлөө” дагах нь нийтлэг байдаг. Энэ нь шийдвэр гаргагч өөрөө бүгдийг мэддэг мэт аливаад хандах бөгөөд мэддэггүй гэдгээ огт “мэддэггүй” бөгөөд энэ нь буруу шийдвэр гаргахад түүнийг түлхэж байдаг тул нийгэм үүнээс сэргийлж “зөвлөх, зөвлөх үйлчилгээ” авах боломжийг хангадаг байна. Мөн энэ нь “хуурмаг зөвшлийн үр нөлөө” буюу шийдвэр гаргагч өөрийн бодож санаж байгаагаар бусад хүмүүс бүгд адилхан боддог мэтээр ойлгох эрсдлээс сэргийлж өгөхөд тустай.
2. Нарийн мэргэшсэн мэргэжлийн мэдлэг, ур чадварыг ашиглах боломж олгоно. Шийдвэр гаргагч асуудал бүрийг мэдэх албагүй мөн боломжгүй, гэхдээ шийдэх ёстой байдаг. Шийдэх нийгмийн асуудал нь ганц нэг хүчин зүйлээс бус бүлэг, олон үзэгдэл юмсаас хамаардаг тул чиглэл бүрээр мэргэшсэн хүмүүсээс зөвлөгөө авах боломжийг хангадаг тул зөвлөх авдаг.
3. Эрсдэл, аюулаас сэргийлэн зайлсхийх нэг хүчин зүйл болно. Шийдвэр гаргахуйн аюулгүйн байдлыг хангахад зөвлөх чухал үүрэгтэй бөгөөд зөв шийдвэрийн алхмуудыг хэрэгжүүлэхэд ач холбогдолтой. Мөн тухайн удирдагч-хамт олны хооронд итгэлцсэн, хариуцлагатай, мэргэшсэн харилцаа тогтоход зөвлөх хэрэгтэй.
4. Ажиллах нэмэлт хүч болно. Шийдвэр гаргагч нь хэдийгээр төрийн алба гэсэн хүн хүчний нөөцтэй ч бусад өөр ажлаас ангид байж тодорхой асуудлаар дагнан ажиллах хүн хэрэгтэй болно. Энэ утгаараа зөвлөх нь нэг ёсондоо нэгэн мөрний хүч болж ажиллана. Мөн тухайн асуудлаар нийгмийн санаа бодлыг тусгах, хамтран ажиллах боломжийг хангаж, шийдвэр гаргах үйл явцыг хурдасгахад зөвлөх хэрэгтэй.

ЗӨВЛӨХ, ТҮҮНИЙ ХЭВ ШИНЖҮҮД: ХЭН ХЭРХЭН ЗӨВЛӨДӨГ ВЭ?

Дээр дурдсан бүхнээс харахад зөвлөх чухлаас гадна зайлшгүй хэрэгтэй хүн аж. Тэгэхдээ гол нь “нүдээ олсон” зөвлөх хэрэгтэй. Энэ нь зөвлөхөө сонгохдоо нөгөө л чадахуйн (мерит) зарчимд тулгуурлаж байж олж авах ёстой гэсэн үг. Энэ утгаараа зөвлөх, зөвлөх үйлчилгээнд өндөр шалгуур тавьж, хамгийн сайныг олж авахыг хичээдэг аж.

Harvard Business Review сэтгүүлд хэвлэгдсэн нэгэн ярилцлагад “2 төрлийн зөвлөх байна аа. Эхнийх нь таны бугуйн цагийг хулгайлчихаад танд цаг хэлж өгдөг бол хоёр дахь нь хаан хувцасгүй байна гэдэг

үлгэрийн адил бүх зүйл дээр таны хэлсэн бүхнийг зөвшөөрдөг буюу юу сонсохыг хүсч байгааг тань хэлдэг” (Harvard Business School Publishing, 2019) зөвлөх. Ийм зөвлөх бол үйлдэл, эс үйлдлээрээ шийдвэр гаргах үйл явцыг эрсдэл болгон хувиргаж нийгмийг аюулд учруулна. Тэд шийдэх ёстой асуудлыг буруу тодорхойлох, зорилго зөв ч шийдэх хувилбарыг үндэслэлгүй боловсруулж, буруу сонголт хийх, нийгмийн хомс баялагийг үргүй зарахад нөлөөлөх, эс бөгөөс юу ч хийхгүй идэвхгүй цаг барж суусаар асуудлыг хурцдуулан зөрчил мөргөлдөөнд хүргэхэд нөлөөлнө.

МАНАЙД АСУУДАЛ ЯМАР БАЙНА ВЭ?

Монгол зөвлөхийн хувьд дараах хэв шинж ажиглагддаг.

	ЗӨВЛӨХИЙН ХЭВ ШИНЖ	ҮНДСЭН ШИНЖҮҮД
1	Аялдан дагагч хэв шинж	Даргын юу хүсч байгааг мэддэг, түүнд нь нийцүүлж чаддаг. Тэрээр даргын үзэл бодол, итгэл үнэмшлийг эргэлзээнд оруулах санал зөвлөмж, шүүмж хэлэхгүй. Алдаа гарсан тохиолдолд шийдвэр гаргагч бус нөхцөл байдал, бусад хүмүүс буруутай гэж үзэж, ойлгуулна. Өөрийг нь “хүн болгосонд” талархаж, хувийн үнэнч байдлыг чухалчлах бөгөөд зөвлөх гэхээсээ илүү найдвартай “шадар” туслах нь байна. Гэхдээ тэр “цүнх баригч” биш бөгөөд хүрээлэгсдийн хувьд зөвлөх статусаа өргөж байхыг хичээнэ.
2	Хувиа бодож, довоо шарлуулагч хэв шинж	Энэ ажил мөнхийн бус, тэгээд ч төрийн төлөө оготно боож үхдэггүй гэдгийг “ойлгодог”. Өөрөө санаачлага гаргаж, илүү хөдөлгөөн хийдэггүй. “Дуугүй хүн сүрлэг” зарчмаар ажиллана. Нэгэнт идэвхтэй үйлдэл, эс үйлдэл хийхгүйгээс хойш бусдад саад болж дургүйг нь хүргэхгүй “нуруутай”, “төлөв” нэр зүүнэ. Зөвлөхийн статус нь түүнд хэрэгтэй, ашигтай холбоо сүлбээ, нэр хүнд өгдөг тул түүндээ дуртай ч илүү боломж гарвал алдахгүй.
3	“Романтик” хэв шинж	Сайн зүйл хийх хүсэлтэй, бас гадаад дотоодод гайгүй боловсрол эзэмшсэн, их зүйлийг хурдан хийх хүсэлтэй ч яаж хийх, монголын “онцлог” нийцэх арга замаа “олдоггүй”. Гадаад орны туршлага их ярина, салбартаа танигдаагүй тул баг бүрдүүлж үл чадна. Санаачлагатай ч бодлого, шийдвэр газарт хэрхэн бууж хэрэгжих тал дээр туршлагагүй. Мөн “амбиц” ихтэй бөгөөд шийдвэр гаргагчид өгч буй зөвлөгөө нь макро түвшний, системийг бүхэлд нь өөрчлөх радикал шинжтэй. Санал зөвлөгөө нь үр дүнд хүртлээ цаг хугацаа, хүчин чармайлт шаарддаг тул “сонгуулиас сонгуулийн хооронд” 4 жилийн сэтгэлгээтэй шийдвэр гаргагчид бол ийм зөвлөмж ашиггүй.
4	“Шоучин” хэв шинж	Өөрийн боссын “... ивээл дор” зэрэг олны анхаарал татсан “кампанит” ажил хийнэ. Тэдгээр нь үр дүн багатай, нэг удаагийн шинжтэй. Санаачлагатай. Ихэвчлэн олноо танигдсан хэн нэгэн байдаг тул зөвлөхийн статусаасаа илүү өөрийн хувийн статуст ач холбогдол өгнө. Богино хугацаанд түр зуурын үр дүн авчрахад чиглэсэн санал зөвлөмж өгөх нь түгээмэл. Системийг өөрчлөх том санал зөвлөмж гаргахгүй бөгөөд өнгөн засал, үзэмжид тулгуурлан ажиллана.
5	“Шинжээч” хэв шинж	Хариуцлагатай, асуудлыг нухацтай ул суурьтай судлаж, олон талаас нь харж байж зөвлөдөг. Ажлын эрх ашгийг нэгдүгээрт тавьдаг зарчимч, шийдвэр гаргагчид хүндлэгддэг, нөлөөлж чаддаг. Асуудлыг олон талаас харж, өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн хэлхээнд дүн шинжилгээ хийдэг тул системийг өөрчлөх зэрэг радикал санал гаргах чадвартай. Өөрийн салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн тул асуудлыг шийдэхэд багийн оролцоог хангаж чадна.

Дээр дурдсан хэв шинжүүдээс аль нь манайд давамгайлж, шийдвэр гаргах аюулгүй байдлыг эрсдэлд оруулж байгааг уншигч та өөрөө эргэцүүлэн бодно биз ээ.

Хамгийн гол нь төр улс, ард түмний хувь заяатай холбоотой шийдвэр гаргахад нөлөөлж байдаг зөвлөхүүдийг өнөөгийнх ишг тодорхойгүй, эрсдэлтэй байдлаар бус улс орны язгуур эрх ашигт нийцүүлсэн хариуцлагатай тогтолцоог бүрдүүлэх, түүнд тавих шаардлага, хариуцлагыг тодорхой болгож, “нүдээ олсон” зөвлөхтэй байж, “загатнасан газар маажих ишг” бодлого шийдвэр гаргадаг болох хэрэгтэй байна даа, бидэнд.

2019 оны 6-р сар

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ | ЗОРИГЖУУЛНА | МЭДЭЛЖҮҮЛНЭ

ДАВАА ГАРАГ БҮР



НЭГ УЛИРЛЫН ҮНЭ
30.000₮

МОНГОЛ ШУУДАН
7007-8916

WWW.MONGOLPOST.MN



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 21 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл:
2019.06.16-ны дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://jargaldefacto.com/category/12>

МАЛЫГ ХӨЛӨӨР НЬ ГАРГАХГҮЙ

Үйл явдлын товч:

Мах, шатахуун зэрэг нь манай инфляцийн өсөлтөд нөлөөлдөг гол бүтээгдэхүүнүүд төдийгүй иргэдийн хэрэглээний зардлын ихээхэн хэсгийг бүрдүүлдэг. Өнгөрсөн оны сүүлээс дэлхийн зах зээл дээрх махны үнийн өсөлттэй холбоотойгоор экспорт огцом нэмэгдэж дотоодын махны үнэ өсч эхэлсэн. Харин сүүлийн үед малыг хөлөөр нь гаргах асуудал махны экспорттой холбоотойгоор олон нийтийн дунд яригдаад байна. Улмаар өнгөрсөн өдрүүдэд Засгийн газар хэлэлцэж малыг хөлөөр нь гаргах буруу гэсэн байр суурийг мэдэгдлээ.

Дүгнэлт тайлбар:

Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан: “Малыг хөлөөр нь гаргах буруу гэж Засгийн газар үзсэн. Одоогоос хэдэн жилийн өмнө манайхаас малыг хөлөөр нь гаргах, мал махны экспортын хэмжээг нэмэгдүүлэх тухай тушаал гарсан юм билээ. Тухайн үеийн шийдвэрт үржлийн бус эр хонь, ямааг хөлөөр нь гаргаж болох боломжийг нээж өгсөн. Гэхдээ энэ хэрэгжээгүй, мал хөлөөрөө гадагш гараагүй байгаа. Ингээд Засгийн газрын хуралдаанаар Монголын мах, ноос ноолуур, хүнсчдийн холбооны санал санаачилгыг харгалзан үзэж, Засгийн газрын өмнөх шийдвэрийг хүчингүй болгох шийдвэрт хүрч байна. Бид аль болох дотооддоо өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадагш гаргах бодлого барьж байна” гэж мэдэгдсэн.

Манай төр засаг тодорхой, урт хугацааны бодлогын дагуу биш, аль нэг хүний хувийн эрх ашигтай холбоотой шийдвэрүүд гаргаад байгаа. Ч.Улаан сайдын хэлснээр өнөөдрийг хүртэл нэг ч малыг хөлөөр нь гаргаагүй гэж байгаа. Гаргаж эхлээгүй байтал энэ бодлого нь ийнхүү өөрчлөгдөөд байна. Мөн Ч.Улаан



сайдын дүүгийн компани малыг урагш гаргах ажлыг хариуцаж байгаа гэж хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж байгаа.

Монголын эдийн засгийг хөгжүүлэх хамгийн чухал асуудал нь эдийн засгаа төрөлжүүлэх юм. Энэ хүрээнд хамгийн түрүүнд яригддаг салбар нь мэдээж хөдөө аж ахуйн салбар. Нөгөө талаас үүнд гадаад худалдааны нэгдсэн бодлого дутаад байна уу гэж харж байна. Эдийн засагч Дани Родрикийн хэлж байгаагаар худалдааны бодлого гэдэг харахад маш энгийн зүйл боловч үнэн хэрэгтэй энэ нь маш төвөгтэй гэж байгаа юм. Үүнд маш нарийн нюанстай бодлого хэрэгтэй. Үүнийг мэргэшсэн хүмүүс л гаргах боломжтой. Манайд гадаад худалдааны чиглэлээр судалгаа хийдэг судлаачид ховор байна. Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль гарахын өмнө заавал судалгаа хийгдсэн байх ёстой гэж байгаа. Үүнтэй адил манай бүх л бодлого заавал өмнө нь судалгаа хийгдсэн байх ёстой.

Англо-саксоны орнуудад нэг зарчмыг хатуу баримталдаг. Энэ нь баримт нотолгоон дээр суурилж шийдвэр гаргах ёстой. Манайд энэ хэрэгжихгүй байгаа учраас л энэ бүх асуудлууд гараад байна л даа. Мерит буюу мэргэжил, ур чадвар, авьяас дээр суурилсан томилгоо, төрийн албанд хүмүүс ажиллахаас л энэ бүх ажил эхэлнэ гэж хардаг.

Махны экспортыг хязгаарлавал эдийн засгийг төрөлжүүлэхийн эсрэг үйлдэл болох болов уу. Мэдээж нэмүү үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн болгоод гаргавал Монгол улсад ашигтай. Гэхдээ

одоогийн нөхцөл байдалдаа аль нь тохиромжтой вэ гэвэл тодорхой хэмжээнд хөлөөр нь гаргах байж болох юм.

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ХУУЛЬ ХЭНД АШИГТАЙ ВЭ?

Үйл явдлын товч:

Цаг үеэ дагаад технологийн хөгжил дэвшилтэй хамтхувьсанөөрчлөгдөжбуйөргөннэвтрүүлгийн салбарын үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын асуудал ойрын үед нийгмийн сүлжээгээр ихээхэн яригдлаа. Өнгөрсөн өдрүүдэд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төслийг УИХ-ын байнгын хороодоор хэлэлцэн дэмжиж УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр болоод байна.

Дүгнэлт тайлбар:

Өнөөдрийг хүртэл өргөн нэвтрүүлгийн тухай хууль гэж байгаагүй. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль байгаа ч энэ нь яг л үүндээ зориулсан хууль. Бусад 140 гаруй үйл ажиллагаа эрхэлж байгаа радио, телевизүүдэд зориулсан хууль байхгүй явж ирсэн. Бусад орнуудын туршлагаас харсан ч энэ хуулийг батлах нь бол зайлшгүй. 2016 онд хамгийн анх энэ хуулийн төсөл орж ирж, өнөөдрийг хүртэл хэлэлцэгдэж байна.

Асуудал нь IPTV буюу телевизүүдийг дамжуулж байгаа компаниуд байгаа. Эдгээр нь хэрэглэгчдээс төлбөр авдаг ч орлогоо буцааж телевизүүдтэй хуваалцдаггүй байна. Энэ хууль гарснаар контент үйлдвэрлэж байгаа телевизүүдэд илүү боломж олдох байх. Энэ хуулийн дагуу IPTV бүх телевизүүдтэй гэрээ хийж, төлбөрөө тохирох ёстой гэж байгаа. Гадны телевизүүдэд тэртээ тэргүй мөнгө өгч байгаа. Харин монголынхоо телевизүүдэд хуваалцахгүй байна. Хуулийн төслийг уншиж үзэхэд айл бүрээс 20 мянган төгрөг авна гэсэн заалт байхгүй байсан. 20 мянган төгрөг авна гэсэн асуудал нийгмийн сүлжээгээр явж байсан нь худал мэдээлэл юм.

Ер нь телевизүүд чанартай контент бүтээхийн тулд хаанаас орлого олох вэ гэдэг асуудал байгаа. Реклам сурталчилгааны зах зээлд 140 гаруй телевиз хуваагаад авахаар чанартай контент үйлдвэрлэх боломжгүй. Яагаад ийм олон телевизид тусгай зөвшөөрөл өгсөн бэ? Энэ олон телевизүүд бүгд стандарт шаардлагаа хангаж байгаа юу? Үүнийг нэг бүрчлэн эргэж шалгах ёстой байх. Хоёрдугаарт, зохиогчийн эрхийн асуудал байна. Хэрвээ зохиогчийн эрхийг зөрчсөн контент гарч л байгаа бол тэр контентуудыг хянаад телевизүүдийг хаадаг арга хэмжээ авах хэрэгтэй. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар энэ тал дээр уг нь их дуугарч, ажиллах ёстой.

Хуулийн төсөл дээр бол Үндэсний нэвтрүүлэг хөгжүүлэх сан гэж бий болгоно гэсэн байгаа. Энэ сангийн гол зорилго нь улсын төсвийн эх үүсвэрээс тодорхой контентуудыг санхүүжүүлэх юм. Үндэсний соёл урлагийг сурталчлах зорилготой. Гэхдээ МУ-д энэ мэтчилэн сангууд яаж байгааг бодох хэрэгтэй байх. ЖДҮХС шиг тодорхой нэг эрх мэдэлд ойрхон байгаа телевизийг дэмжихэд зарцуулагдчихгүй байгаа гэсэн болгоомжлол төрж байна. Хэрвээ ийм сан байгуулж л байгаа бол яаж бие даасан, хараат бусаар ажиллах вэ гэдгийг зохицуулах ёстой. Энэ тухай хуулийн төсөлд байхгүй. Хуулиндаа болохоор ЗГ-аас журам гаргаад энэ асуудлыг шийднэ гэсэн байгаа. Энэ төрлийн хуульд дандаа тодорхой асуудлыг журмаар шийднэ гэж бичсэн байдаг. Журмаар шийднэ гэдэг нь бидний сонгоогүй хүмүүс үүнийг нь батлаж, өөрсдийнхөө эрх ашигт тааруулдаг юм. Хуулийн цоорхой ялангуяа журмаар дамжиж хэрэгжээд байна уу гэж хардаг. Нарийвчилсан зохицуулалтыг хуулин дээр нь л хийх ёстой.

ИРГЭНИЙ НИЙГМИЙН ДУУ ХООЛОЙ ХУМИГДАХ УУ?

Үйл явдлын товч:

2018 оноос төрийн бус байгууллагуудын эрх зүйн орчныг шинэчлэх хуулийн төсөл боловсруулах ажил эхэлсэн. Засгийн газраас ТББ нэрээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн байгууллагуудыг цэгцэлнэ, ТББ-ууд гадны төлөөлөгчийн газрууд шиг үйл ажиллагаа явуулж байна гэх мэт мэдэгдлүүдийг хийж байсан. Улмаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өнгөрсөн оны сүүлээр анх удаа “Ашгийн бус хуулийн этгээдийн тухай хуулийн шинэчилсэн найруулга”-ыг боловсруулснаа танилцуулсан. Энэ үеэс иргэний нийгмийн байгууллагууд хуулийн төсөлтэй танилцаж санал хүсэлтээ хүргүүлснээр яамнаас холбогдох өөрчлөлтүүдийг хийж эцсийн хувилбарыг танилцуулаад байна.

Дүгнэлт тайлбар:

Зөвхөн манайд энэ хуулийг ярьж байгаа юм биш дэлхий нийтийг хамарсан гэж хэлж болно. Сүүлийн 4 жилд дэлхийн 60 гаруй оронд ТББ-тай холбоотой хуулиудын шинэчилсэн найруулга батлагдаж байгаа. Шалтгаан нь ардчиллаас ухрах процесс эхэлж байгаа. 1990 оноос хойш ардчиллын 3 дахь давалгаа гэж бий болсон. Энэ давалгаагаар нийтдээ 30 гаруй ардчилсан орон байсан бол 115 гартлаа өссөн. Энэ давалгаа хүчтэй явж байгаад 2006 он гээд зогссон. Харин үүнээс хойш буцаад ардчиллаас ухрах үйл явц эхэлсэн гээд байгаа юм. Ардчиллын хамгийн чухал институтийг нураах, хаах, боох байдлаар хэрэгжиж байна.

Иргэний нийгмийн байгууллагын дуу хоолойг хаах ажиллагаа маш хүчтэй хэрэгжиж байна.



Үүний манлайлагч нь ОХУ. ОХУ-д гадаадын агентын тухай хууль гэж батлагдсан. Энэ хууль батлагдаад л өөр олон оронд батлагдаад эхэлсэн. ТББ гэдэг нэрээр гаднаас санхүүжилт аваад гадны үзэл бодлыг олон нийтэд сурталчлаад байна гэсэн шалтгаантай. Үүнийгээ терроризм, мөнгө угаахтай холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой гэж халхавчлаж байна.

2017 онд дэд сайд Б.Энхбаяр хуулийн төслийг санаачлахдаа яг л ийм зүйл ярьж байсан л даа. Б.Энхбаяр дэд сайдын хэлж байгаагаар МУ-ын ТББ-уудын 80 орчим хувь нь гадаадаас санхүүжилт авдаг. Үлдсэн 20 хувь нь дотоод гишүүдээсээ санхүүжилт авдаг гэж хэлсэн байгаа. Энэ хуулийн төсөл дээр ТББ-ууд маш идэвхтэй саналаа хэлж байгаа. МУ-д ТББ-ын эрх зүйн зохицуулалтын хувьд бүрхэг зүйлс их байгаа.

*Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв
Тоймын бүрэн эхийг jargaldefacto.com вебсайтаас үзэх
боломжтой.*

GOOGLE STORE



APP STORE





EVSEG

Mongolian Premium Cashmere

Эх орны үнэт түүхий эд цэвэр монгол ямааны болох ноолуур, тэмээний ноосыг европын өндөр чанартай туслах материал, технологиор чанарын өндөр түвшинд боловсруулж, мэргэжлийн ажилчид инженерүүд, дизайнеруудын сэтгэл шингэсэн ур ухаанаар бүтээгддэг, үндэсний брэнд компани юм.

Эвсэг | Нирун брэндийн үйлдвэрийн төв дэлгүүр нь 1,720 м.кв бөгөөд сүлжмэл, нэхмэл, оёмол бүтээгдэхүүний 1,500 гаруй загвар, өнгөний өргөн сонголттойгоор хэрэглэгчиддээ үйлчилж байна. Ноолуурын үйлдвэр нь анхан шатнаас эхлэн эцсийн бэлэн бүтээгдэхүүн хүртэлх бүх дамжлагатай, нийт 900 гаруй ажилчидтай цогц үйлдвэрлэл явуулдаг.



ҮЙЛДВЭРИЙН ТӨВ ДЭЛГҮҮР

Зайсан явах замд, Богдын хааны ордон музейн баруун урд
Tel: 11 343595, 9995 3027



ЭВСЭГ | НИРУН ДЭЛГҮҮР

Төв номын сангийн хойно / хуучнаар "Бамбарууш кафе" /
Tel: 11 330217, 9995 3027



УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР САЛБАР

Улсын их дэлгүүр 2-р давхар
Tel: 11 343595, 9995 3027